



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

20 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 518

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэсний аудитын газрын харьяа Булган, Сэлэнгэ, Увс, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 98,408,330.00 /ерэн найман сая дөрвөн зуун найман мянга гурван зуун гучин/ төгрөгийн балансын үнэ бүхий 4 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга Ц.Ганболд, Булган, Увс, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
518... дугаар тогтоолын хавсралт

Үндэсний аудитын газрын харьяа Булган, Сэлэнгэ, Увс, Дорнод аймаг дахь
Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км	Балансын үнэ (төгрөг)	Хуризмтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээгч бослолт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Балансад бүртгэлтэй байгууллага
1	Ландкрузер-80, 85-35 БУЛ, арал№FZJ800164738	1996/ 2010	698231	30,000,000.00	30,000,000.00	0	0	1,000,000.00	Булган Төрийн аудитын газар
2	Прадо-120, 00-03 СБА, арал№TRJ1205079771	2007/ 2013	536000	50,000,000.00	50,000,000.00	0	0	2,000,000.00	Сэлэнгэ Төрийн аудитын газар
3	УАЗ-315122, 45-27 УВА, арал№315100В0588535	2011/ 2011	845625	18,200,000.00	18,200,000.00	0	0	1,000,000.00	Увс Төрийн аудитын газар
4	Старекс, 01-56 ДОР, арал№KMJVVWVHNZHP2U U409281	2002/ 2011	678960	208,330.00	208,330.00	0	0	500,000.00	Дорнод Төрийн аудитын газар
	Нийт дүн			98,408,330.00 /ерэн найман сая дөрвөн зуун найман мянга гурван зуун гучин/	98,408,330.00 /ерэн найман сая дөрвөн зуун найман мянга гурван зуун гучин/	0	0	4,500,000.00 /дөрвөн сая таван зуун мянган/	